



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/741

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны XVII/01 тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын нийтийн эзэмшлийн зам талбайн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн гаднах өнгө үзэмжийг сэргээн засварлах, биеийн тамирын талбай тохижуулах ажилд шаардагдах 2,792,500 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн гаднах өнгө үзэмжийг сэргээн засварлах, биеийн тамирын талбай тохижуулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавин ажиллахыг Булган Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал (Д.Баттуяа)-д үүрэг болгосугай.

3.Тус арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалт” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

